## БҮРДҮҮЛЭЛТИЙН ЦАХИМ ТӨВИЙН ДАРГА ЭРДЭНЭХҮҮГИЙН ЛХАГВАСҮРЭНГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

### Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэл тийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1: Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах** | | | | | | | |
| 1. | Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны бичиг баримтын шалгалт хийсэн байдал | Хэрэгжилт гүйцэтгэлээр, | - | 1. Бичиг баримтын бүрдүүлэлтийн хэвийн үйл ажиллагааг хангаж, бичиг баримтын шалгалтыг горимын шаардлага, хууль тогтоомжийн хүрээнд бүрэн алдаагүй хийж, зохих төлөвт бүрэн байршуулсан байна.<br>2. Судалгаа, дүн шинжилгээнүүдийг гаалийн бүрдүүлэлтийн, орлогын, горимын, хөнгөлөлт чөлөөлөлтийн гэх мэт олон чиглэлээр хийж, удирдлагыг мэдээллээр хангаж, бүрдүүлэлтэд гарч байгаа алдаа дутагдалыг засч, үйл ажиллагаар сайжруулсан байна.<br>3. Гаалийн газар, хороодын удирдлагуудтай харилцан мэдээлэл, | 1. Өдөр тутмын үйл ажиллагааг ГУАБ нар БТКУС кодоор хувиарлан авч хяналт тавин ажиллаж, нийт ГУБ нарыг 5 багт хувааж 1 сараар ээлжлүүлэн БТКУС, гомдол маргаан болон мэдүүлгийн алдааг давхар хянаж ажиллаж байна.<br>• Барааны тоо 13.3 хувиар өссөн (902.8 → 1,022.9 мянга),<br>• Татварын орлого 11.1 хувиар өссөн (2,676.7 → 2,974.6 тэрбум төгрөг),<br>• Мэдүүлгийн тоо 3.8 хувиар буурсан (198.1 → 190.6 мянга) үзүүлэлттэй байна.<br>Давхар хариуцсан ажлын төлөвлөгөөний дагуу 1 ГУАБ, 2 ГУБ хариуцан ажилладаг ба 7 хоног, сарын эцэст төлөвийг шахаж ажиллаж хэвшсэн.<br>Гаалийн бүрдүүлэлтийн хэвийн үйл ажиллагааг хангах санал гаргаж, зөвлөмж, чиглэл хүссэн 20 дотоод зурвасыг холбогдохнэгжүүдэд хүргүүлэн ажилласан.<br>2. Тайлант хугацаанд гаалийн үнийн хяналтын зорилгоор автомашинд хамаарах 6 төрлийн судалгааг хийж батлуулан судалгаанд үндэслэн 13.5 | 2025.01.01<br>2025.06.10 | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | солилцож, хамтран ажилласан байна.<br>4. Гаалийн газар, хороодод хийгдэж байгаа экспортын барааны бичиг баримтын бүрдүүлэлтийг шилжүүлэн хийж эхлэх үед бэлтгэл ажлыг ханган, экспортын бүрдүүлэлтийг хийж эхэлсэн байна. | тэрбум төгрөг, ЗҮГГ-тай хамтарч хийсэн хил орчмын үнийн судалгааны дагуу 31.1 тэрбум төгрөгийг нэмж төвлөрүүлсэн байна.<br>3. Замын-Үүд гаалийн газрын холбоо баригчаар дамжуулан 26 удаагийн хамтарсан манифестийн лавлагаа авч 598.9 сая төгрөг нэмж ногдуулж төлүүлсэн.<br>4. 2025 оны 2 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн СЭГГ, ЧХОУНБГГ, БөГГ, УвГГ, УХШИГГ, ЗАГХ болон ХАГГ-т хийгдэх экспортын барааны бичиг баримтын шалгалтыг горимт харгалзахгүй хийж эхэлсэн. | | |
| 2. | Хууль ёсны гадаад худалдааг хөнгөвчлөх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ | Хэрэгжилт, гүйцэтгэлээр, | - | 1. Худалдааг хөнгөвчлөх чиглэлээр гарсан бодлогын баримт бичиг, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах, бараагаа өөрөө мэдүүлэх үйл ажиллагааг нэмэгдүүлэх, санал боловсруулан танилцуулсан байна.<br>2.Бичиг баримтын бүрдүүлэлтэд зарцуулсан дундаж цаг хугацааг өмнөх оны мөн үеэс 1,5 хувиар бууруулсан байна.<br>3 Гаалийн бүрдүүлэлтийн автоматжуулсан системийн сайжруулалт, өөрчлөлт, хөгжүүлэлтийн саналыг тухай бүрт нь гарган, МТТ-д хүргүүлсэн байна. | Худалдааг хөнгөвчлөх чиглэлээр гарсан бодлогын баримт бичиг, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах, бараагаа өөрөө мэдүүлэх үйл ажиллагааг нэмэгдүүлэх, санал боловсруулан танилцуулсан байна.<br>-1.Тайлант хугацаанд импортын гаалийн бүрдүүлэлт өмнөх оны мөн үеэс 5.93 хувиар өссөн бөгөөд импортын гаалийн мэдүүлгийн хяналтын төлөвт биет шалгалтаас чөлөөлөгдөх хувь буурсан байна.Тайлант хугацаанд импортын гаалийн бүрдүүлэлт 36.2 хувиар өссөн бөгөөд импортын гаалийн мэдүүлгийн хяналтын төлөвт биет шалгалтаас чөлөөлөгдөх хувь буурсан байна. Тайлант хугацаанд 4,889 аж ахуйн нэгж, иргэн 170,587 барааны 21,477 мэдүүлгийг цахимаар мэдүүлэн 371.4 тэрбум төгрөгийн барааг улсын төсөвт төвлөрүүлсэн. Цахимаар өөрөө хамгийн их мэдүүлсэн доорхи 10 ААН, иргэн нийт өөрөө мэдүүлсэн мэдүүлгийн ногдуулсан татварын 45 хувийг, мэдүүлгийн 15.1 хувийг тус тус ээлж | 2025.01.01<br>2025.06.10 | 96% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | өмнөх оноос бүрдүүлэлтийн тоо нь өссөн байна.<br>- БЦТ-өөс өөрөө мэдүүлэх үйл явцыг дэмжих зорилгоор гаалийн бүрдүүлэлтийн талаар тайлбарласан видео контентийг Олон нийттэй харилцах албатай хамтран гаргасан, 2025 онд Япон улсаас импортолж байгаа дуудлага худалдааны бичиг баримттай, шалгуур үнийг хангасан машины судалгааг 2 удаа, Lexus-HS250h, Toyota Vellfire. Alphard маркийн автомашины шалгуур үнийн судалгааг 1 удаа хийж нийт 204 үнийн мэдээллийг системд оруулж нэвтрүүлснээр автомашиныг систем үнэлсэн нь цаг хугацааг хэмнэсэн, худалдааг хөнгөвчлөхөд ач холбогдол өгсөн.<br>- МТГ-т бүрдүүлэлтийн алдааг багасгах зорилгоор хүнсний барааны хугацааг программаар шийдэх санал явуулж, гаалийн байгууллагад хүнсний барааг мэдүүлэхэд тухайн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэсэн огноо, хадгалах хугацаа, дуусах огноог нөхөн бичих талбар шинээр нэмэх, тухайн талбарт мэдээлэл оруулаагүй тохиолдолд гаалийн мэдүүлэг илгээгдэхгүй болох ингэснээр нэмэлт өөрчлөлт, программын шинэчлэлд санал өгч оруулан алдааг багасгах хариуцлагыг нэмэгдүүлэн ажиллана.<br>2. Бичиг баримтын бүрдүүлэлтэд зарцуулсан дундаж цаг хугацааг өмнөх оны мөн үеэс 1,5 хувиар бууруулсан байна.<br>Бичиг баримтын шалгалт хийхэд нэгж бараанд зарцуулсан хугацааны дунджийн өөрчлөлтийг төлөв тус бүрээр авч үзэхэд тайлант хугацаанд "ногоон" төлөвийн нэгж бараа шалгах хугацаа 14.4 хувиар, "улбар шар" төлөвийн нэгж бараа шалгах хугацаа 14.6 хувиар, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | "улаан" төлөвийн нэгж барааг шалгах хугацаа 1.2 хувиар, бараанд хийх шалгалт 2,6 хувиар бууруулсан ололтой. | | |
| 3. | Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний үйл ажиллагаа | Хэрэгжилт, гүйцэтгэлээр, | - | 1. Шинээр батлагдсан ГБМ-ний үйл ажиллагааны журмын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр ханган, хагас бүтэн жилээр засварт буцаалтад судалгаа, дүн шинжилээ хийж, түгээмэл гаргасан алдаанд суурилсан сургалтыг 2 удаа зохион байгуулан ажиллана<br>2. Барааны бичиглэл ижилсгэх чиглэлээр гарын авлага гаргаж, нэг болон ижил төрлийн зарим барааны бичиглэлийг жигдрүүлэн холбогдох судалгаа, дүн шинжилгээг хийсэн байна.<br>3. Мэдүүлэгчийн гаргасан алдааг илрүүлсэн тоо, нийт бүрдүүлэлтэд эзлэх хувийг өмнөх оны мөн үеэс 1 хүртэл хувиар нэмэгдүүлнэ.<br>4. Мэдүүлгийн алдаанд дүн шинжилгээ хийж ГЕГ-ын холбогдох нэгжтэй санал солилцон ажилласан байна. | 1. Тайлант хугацаанд онлайнаар 1, танхимаар 3 удаагийн сургалтыг зохион байгуулсан байна. Үүнд:<br>- "Гаалийн зуучлагч байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих журам"-ыг 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/19 дугаар тушаалаар 2025.04.11-ний өдөр Zoom аппликейшн ашиглан онлайн сургалтыг зохион байгуулж ажилласан. Сургалтад 24 зуучлагч байгууллагын 154 гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн хамрагдсан.<br>- ГЕГ-ын сургалтын төвтэй хамтран ГБМ-ийг чадавхжуулах чиглэлд ГБМ-ий давтан сургалтад 2 удаа "гаалийн тариф, гарал үүслийн дүрмийн хэрэгжилтэд гарч буй алдаа, цаашид анхаарах асуудлууд" сэдвээр,<br>- ГБМ-ний анхан шатны эрх олгох сургалтад 1 удаа "гарал үүслийн дүрэм, гаалийн тарифын хэрэгжилт, анхаарах асуудлууд" сэдвээр танхимын сургалтыг тус тус зохион байгуулсан.<br>2. 103 ялгаатай ангиллын кодод хамаарах барааны ерөнхий бичиглэлийг нэгтгэн, ГУБ нарын компьютерт байршуулан, бичиглэлийг ижилсгэж ажиллаж байна.<br>3. Засварт буцаалт өссөн нь ГУБ нарын мэдүүлгийн алдаа илрүүлэлт нэмэгдэж байгаагаас гадна шинэ ГБМ алдаа, өөрөө мэдүүлэх явц нэмэгдэж байгаатай холбоотой байна. Мөн засварт буцаалтын тоо өссөн өсөлттэй холбоотойгоор гаалийн зуучлагч байгууллага, ГБМ-нд тавих хяналтыг сайжруулах, хариуцлага тооцох ажлыг эрчимжүүлсэн. Өнгөрсөн оны мөн үед 9 | 2025.01.01<br>2025.06.10 | 88% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | удаа хариуцлага тооцож 2,7 сая төгрөгийн торгууль ногдуулсан байсан бол тайлант хугацаанд 36 гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэнд хариуцлага тооцож 10,8 сая төгрөгийн торгууль ногдуулан барагдуулж, зөрчил, торгуулийн дүнг тус бүр 4 дахин нэмэгдүүлэн ажилласан байна.<br>4. 2025 оны эхний хагас жилээр гаалийн мэдүүлгийн засварт буцаалтын дүн шинжилгээ хийж тайланд тусган, ГЕГ-ын холбогдох нэгжид хүргүүлсэн. Дүн шинжилгээний мөрөөр түгээмэл гаргаж байгаа алдаанд суурилсан сургалтыг 2025 оны 3-р улиралд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. | | |
| 4. | Барааны ангилал, гаалийн үнэ, үнэлгээг үнэн зөв мэдүүлэх, тодорхойлох чиглэлээр зохион байгуулсан ажил | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1. Гаалийн үнийн хяналтыг цахимжуулах ажлын хүрээнд судалгаа хийж, системээс үнэлэх автомашины нэр төрлийг нэмэгдүүлсэн байна.<br>2. Шалгуур мэдээллийг гаалийн бүрдүүлэлтийн автоматжуулсан системд оруулж, барааны гаалийн үнийг системээс автоматаар хянасан байна.<br>3. Импортын барааны хэлцлийн үнийн баазыг бүрдүүлж, гаалийн үнийг бусад аргаар тодорхойлсон нийт барааны 20-аас доошгүй хувийг үнийн мэдээллийн сангийн мэдээлэлд ашигласан байна.<br>4. Автомашины болон хил орчмын үнийн судалгааг хийж, ГЕГ-ын | 1. Өдөрт 1 ГУБ 50 бүрдүүлэлт хийдэг гэж тооцвол 1 байцаагчийн 120 өдрийн ажлыг хийсэн байна.<br>2. Toyota, Prius. Aqua, Sai машины судалгааг 2 удаа, Lexus-HS250h, Toyota Vellfire. Alphard маркийн автомашины шалгуур үнийн судалгааг 1 удаа хийж нийт 204 үнийн мэдээллийг санд оруулсан.<br>3. Нийт импортын барааны 73.4%-ийг /746.4 мянган бараа/ хэлцлийн үнийн аргаар үнэлсэн бол 26.5%-ийг буюу 270.3 мянган барааг бусад аргаар үнэлсэн ба бичиг баримтын бүрдүүлэлтийн үед нэмж төвлөрүүлсэн татварын дүн эхний хагас жилд 160.7 тэрбум төгрөг байна. Үүнээс үнийн мэдээллийн санд байгаа мэдээллийг үндэслэн 91120 бараа үнэлсэн ба нэмж ногдуулсан татварын дүн 50.6 тэрбум төгрөг, бөгөөд гаалийн үнийг бусад аргаар тодорхойлсон нийт барааны 33.9 хувийг үнийн мэдээллийн сангийн мэдээлэлд үндэслэн бүрдүүлэлт хийсэн байна. | 2025.01.01<br>2025.06.10 | 93% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | холбогдох нэгжээр хянуулан баталгаажуулж, гаалийн үнийг тодорхойлоход ашигласан байна.<br>5. Бичиг баримтын бүрдүүлэлтийн үе шатанд барааны ангиллын хяналтыг хэрэгжүүлж, ангиллын луйврыг илрүүлж ажилласан байна.<br>6. Цахимжуулах барааны бичиглэл ижилгэсэн байна.<br>7. Барааны лавлах санг баяжуулж ажилласан байна.<br>8. Алба хаагчдын хэрэгцээ шаардлагыг тодорхойлон 2025 оны сургалтын төлөвлөгөөг боловсруулан төвийн даргаар батлуулан хэрэгжилтийг нь хангаж ажилласан байна. | 4. Автомашинд хамаарах 6 төрлийн судалгааг хийж, гаалийн үнийн хяналтын зорилгоор ашигалн 13.5 тэрбум төгрөг татвар нэмж төвлөрүүлсэн, мөн хилийн үнийн судалгаанд үндэслэн гаалийн үнийг тодорхойлон нэмж төвлөрүүлсэн татварын дүн 31.1 тэрбум төгрөг байна.<br>5. Зүйл 90.18-д хамаарах тарифын ялгаатай хувь хэмжээ бүхий 27 барааны кодыг засуулж барааны кодыг зөв болгон 8 280 125.2 төгрөгийн гаалийн татвар, нөхөн төлүүлсэн. БТКУС-ийн 94036000 кодод хамаарах 04-2151011-25-I00117 дугаарын мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн 3 барааны ангиллын кодыг хянаж, 1 468 198,1 төгрөгийн татварыг тус тус нөхөн төлүүлсэн байна.<br>6. Дээрх 5 нэр төрлийн автомашины мэдээллийг ижилтгэж хийснээр 21 дүгээр хүснэгт дэх мэдээллийг программ таних боломж бүрдэж, шалгуур үнийн сангийн ажиллах боломж бүрдэж системээс үнэлэх боломжтой болж байна.<br>7. 2025 оны эхний хагас жилд лавлах санд 162 оноосон нэр, 1490 үйлдвэрлэгч, 1164 хөдөлгүүрийн багтаамж, 15718 моделийн төрөл, 10658 кузовын мэдээллийг лавлах санд байна. Бүх төрлийн автомашины бичиглэл ижилсгэж, барааны гаалийн мэдүүлэг нөхөн бичих хугацааг бууруулсан, автомашины бичиглэл ижилтгэсэн.<br>8. Сургалтын үр дүн. Мэргэжлийн мэдлэг, хууль эрх зүйн мэдлэг сайжирсан, Олон улсын туршлага олж авсан /БНХАУ, БНСУ, ДГБ / давхардсан тоогоор 24 удаагийн сургалт сургалт зохион байгуулсан, сургалтууд нь ажилтнуудын ур чадварыг дээшлүүлж, байгууллагын үйл ажиллагаа | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сайжруулахад бодит хувь нэмэр оруулсан. | | |
| **Зорилт 2: "Улсын хилээр хууль бусаар бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэх"** | | | | | | | |
| 5. | Гаалийн бүрдүүлэлтэд гарсан алдаа болон зөрчил илрүүлэлт, шийдвэрлэлт, алдааг бууруулах чиглэлээр зохион байгуулсан ажил | Илрүүлсэн зөрчлийн тоо, нөхөн төлүүлсэн татварын дүн, торгуулийн дүн | - | 1. Мэдүүлэгчийн гаргасан алдааг илрүүлсэн тоо, нийт бүрдүүлэлтэд эзлэх хувийг өмнөх оны мөн үеэс 1 хүртэл хувиар нэмэгдүүлнэ.<br>2. Бичиг баримтын шалгалтын явцад илрүүлсэн зөрчлийн тоо, нөхөн төлүүлсэн татвар, торгуулийн дүнг өмнөх оны мөн үеэс 2 хүртэл хувиар нэмэгдүүлнэ.<br>3. Барааны ангилал, үнэлгээний луйвраас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж ажилласан байна.<br>4. Гааль зөвшөөрөв төлөвөөс засварт буцааж мэдүүлэгт засвар оруулсан байдлыг өмнөх оны мөн үеэс 1 хүртэл хувиар бууруулна. | 1. 2025 оны эхний хагас жилд 26937 мэдүүлэгчийн гаргасан алдааг засварлуулсан нь 2024 оны мөн үеэс 20.3 хувиар нэмэгдсэн ба гаалийн хууль тогтоомжид заасан эрхээ хэтрүүлсэн 32 зуучлагч байгууллагын 36 гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэнд ЗТХ-ийн 11.21.14-д заасны дагуу тус бүр 300000 төгрөгөөр торгосон ба энэ нь өмнөх оны мөн үеэс 27 ГБМ буюу 27 зөрчлөөр 4 дахин нэмэгдсэн.<br>2. БЦТ-ийн гаалийн улсын байцаагч нар 2025 оны 06-р сарын 10-ны өдрийг дуусталх хугацаанд гаалийн бүрдүүлэлтэд бичиг баримтын шалгалт хийх явцдаа Гаалийн тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль зөрчсөн нийт 213 зөрчлийг илрүүлэн Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулан Зөрчлийн тухай хуулийн 9 зүйлчлэлээр нийт 213 зөрчлийн 267.70 сая төгрөгийн татварыг нөхөн төлүүлэн, 245.40 сая төгрөгөөр торгож улсын төсөвт 513.11 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн.<br>2024 оны мөн үеэс зөрчлийн тоо 158 буюу 287.27 хувь, нөхөн төлсөн татварын дүн 248.10 сая төгрөг буюу 1265.84 хувь, торгуулийн дүн 179.25 сая төгрөг буюу 270.98 хувиар тус тус нэмэгдсэн.<br>2025 эхний хагас жилд БЦТ-ийн ГУБ нар өөрсдөө шалган шийдвэрлэсэн 121 зөрчил, харьяаллын дагуу шилжүүлсэн 79 зөрчил, рентген зурагт эрсдэл тооцон ГЕГ-ын ШХТ болон харьяа гаалийн газар, хорооны эрх бүхий албан тушаалтан нартай хамтран ажилласны | 2025.01.01<br>2025.06.10 | 89% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үр дүнд 13 зөрчил нийт 213 зөрчил илрүүлэн холбогдох арга хэмжээг авсан. БЦТ-ийн ГУБ нар бүрдүүлэлтэд эрсдэл тооцон 25 бүрдүүлэлтэд БНХАУлсаас холбоо баригчаар дамжуулан хамтарсан манифестийн лавлагаагаар 6 зөрчил, гаалийн лабораторийн дүгнэлт зөрсөн 6 зөрчилд гаалийн хууль тогтоомжид заасан эрхээ хэтрүүлсэн 32 гаалийн зуучлагч байгууллагын 36 гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн нарт тус тус хариуцлага тооцсон.<br>Тайлант хугацаанд зөрчил шалган шийдвэрлэсэн ажиллагаа, материалтай холбоотойгоор прокурорын даалгавар, шаардлага аваагүй байгаа болно.<br>3. Барааны ангилал, үнэлгээний луйвраас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 3 төрлийн арга хэмжээг зохион байгуулж ажилласны дүнд 1-д ГУБ нарын зөрчил илрүүлэх чадвар нэмэгдсэн, 2-д Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний ур чадвар нэмэгдсэн, 3-д Монголын гааль фэйсбүүк богино хэмжээний 3 төрлийн контент явуулан нийт 27550 хандалт авсан.<br>Цахимаар өөрөө мэдүүлэгч байгууллагатай уулзалт зохиосон.<br>4. Гааль зөвшөөрөв төлөвөөс 1883 мэдүүлгийг засварт буцаан алдааг засуулсан нь өмнөх оны мөн үеэсмэдүүлгийн тоо 32-оор нэмэгдсэн буюу нийт мэдүүлэгтэй харьцуулахад 0.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна. | | |
| 6 | Өргөдөл, гомдол, маргааныг шийдвэрлэсэн байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1. Бичиг баримтын бүрдүүлэлтийн үе шатанд ирсэн өргөдөл, гомдолыг холбогдох хуульд заасан хугацаанд нь бүрэн шийдвэрлэн, арга хэмжээ зохион байгуулсан байна. | 1. Үнэ үнэлгээ, ангилалтай холбоотой 769 гомдлыг нягтлан шалгаж, 465 гомдолд ГУБ-ын шийдвэрт гарсан гомдолыг хянасан тухай шийдвэр гаргасан. Гомдол маргаан шийдвэрлэснээр 3,3 тэрбум төгрөгийн татвар нэмэгдэж улсын төсөвт төвлөрүүлсэн байна. ЗГ-ын 11-11 | 2025.01.01<br>2025.06.10 | 96% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2. Шийдвэрийн мэдээллийг кайс систмеийн маргаан шийдвэрийн сан, дуудлагын төвийн шийдвэрлэх жагсаалтад бүрэн оруулсан байна. | төвөөс ирүүлсэн нийт 34 гомдол, 1281 төвөөс ирүүлсэн 3 гомдлыг тус бүрээр нь судлан, зохих арга хэмжээг авч шийдвэрлэсэн болно. 70001280 утсанд давхардсан тоогоор 18391 дуудлага ирсэнийг хүлээн авч шийдвэрлэн ажилласан байна. Гаалийн байгууллагын гомдол, мэдээллийг "Гаалийн лавлах утас 18001281" тусгай дугаарын утсанд нэгдсэн байдлаар төвлөрүүлэх шаардлагатай гэж үзэн БЦТ-ийн 70001280 дугаар 2025 оны 4-р сараас эхлэн 18001281 болж өөрчлөгдсөн. Хүлээн авсан гомдол, мэдээллийг CERP-ийн дуудлагын төв цэсэнд бүрэн бүртгэн ажиллаж байна. Цахим хаягаар хүсэлт 273, гомдол 769 нийт 1042 мэйл ирсэн байна. Цахимаар ирсэн емайлд хариу өгөн хүсэлт, гомдлыг цаг тухай бүр шийдвэрлэсэн. Бусад гомдолыг ААН-тэй нь утсаар болон уулзаж ярилцаж, хууль тогтоомж сурталчилан, танилцуулан таниулж бүрэн шийдвэрлэн ажилласан байна. Тайлант хугацаанд ирсэн бүх өргөдөл, гомдлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан хугацаанд хянаж шийдвэрлэсэн ба шийдвэрлээгүй ААН, иргэнд хариу өгөөгүй, өргөдөл, гомдол байхгүй.<br>2. Үнэ үнэлгээ, ангилалтай холбоотой 769 гомдлыг нягтлан шалгаж, 465 гомдолд ГУБ-ын шийдвэрт гарсан гомдолыг хянасан тухай шийдвэр гаргасан. Үүнээс үнэ үнэлгээтэй холбоотой 459, БТКУС-ын код, ангилалтай холбоотой 6 шийдвэр гарсан. Дээрх шийдвэрүүдийг Кайс системийн барааны ангиллын шийдвэрийн сангийн гомдол шийдвэрийн сан, Гаалийн үнэлгээ шийдвэрийн сангийн маргаан | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шийдвэрийн санд тухай бүр бүрэн бүртгэн ажилласан байна. | | |
| **Зорилт 3: Ногоон хөгжлийг дэмжиж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 7 | Гаалийн бүрдүүлэлтийн горимын хэрэгжилт, гаалийн тариф, гарал үүслийн хяналт | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | 1. Горимын хэрэгжилтийг хангуулж, гаалийн бүрдүүлэлтийн хяналтыг сайжруулах чиглэлээр арга хэмжээ авах, түр горимын дүн шинжилгээ хийн бүрдүүлэлтэд гарч байгаа алдаа дутагдалыг засч, үйл ажиллагааг сажруулсан байна.<br>2. Гарал үүслийн хяналтыг сайжруулж, гаалийн бүрдүүлэлтийн явцад хөнгөлөлттэй болон нэн тааламжтай тарифыг нягтлан шалгаж, дүн шинжилгээ хийж, илэрсэн алдааг засварлаж ажилласан байна. | Тус хугацаанд нийт 5,754.4 сая ам.доллар бүхий 189,631 импортын гаалийн бүрдүүлэлт хийгдсэн нь өмнөх оны мөн үеийн байдалтай харьцуулахад статистик дүн 353.4 сая ам доллар илүү буюу 6.54 хувийн өсөлттэй, 10,624 бүрдүүлэлт илүү буюу 5.93 хувийн өсөлттэй үзүүлэлттэй байна.Нийт экспорт 496.3 сая долларын статистик дүн бүхий 6,051 экспортын бүрдүүлэлт хийгдсэн нь өмнөх оны мөн үеийн байдалтай харьцуулахад статистик дүн 156 сая ам.доллараар их буюу 45.81 хувь, бүрдүүлэлтийн тоо 3,375 буюу 126.12 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.<br>2. Тайлант хугацаанд экспортын 2149 гаалийн мэдүүлгээр 75382.2 мян.ам.долларын, импортын 2253 гаалийн мэдүүлгээр 46126.0 мян.ам.долларын бараанд тус тус бүрдүүлэлт хийгдсэн байна.<br>Гаалийн тухай хуулийн 95.1-р зүйлд зааснаар гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулсан, гаргасан барааг бүрмөсөн орох горимд шилжсэнээр 2025 оны эхний хагас жилд 7 тэрбум 284 сая төгрөгийг татвар улсын төсөвт төвлөрсөн байна.<br>3. 2025 оны эхний хагас жилийн байдлаар Нэн тааламжтай тарифаар 5609.13 сая ам.доллар, ердийн тарифаар 13.09 сая ам.доллар, хөнгөлттэй тарифаар 235.89 сая ам.долларын үнийн дүн бүхий бараанд гаалийн бүрдүүлэлт хийж нийт 2974.61 тэрбум төгрөгийн татварыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. | 2025.01.01<br>2025.06.10 | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Япон-Монголын хоорондын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн дагуу гарал үүсэл шалгахад 2025.03.20-ний өдөр 12-2151003-25-I01484 мэдүүлэг дугаартай Статистик ерөнхий дүн нь 7285.55 ам.долларын бараанд гарал үүслийг нотлох дагалдах бичиг баримтгүй илгээсэн байсныг засварт буцаан 170159241058362 дугаартай гарал үүслийн гэрчилгээг нөхөн хавсаргуулсан. Апта-гийн гарал үүслийг шалгаж байхдаа 05-2151017-25-I00014 мэдүүлэг дугаартай 2 төрлийн бараа нь хөнгөлөлт эдлэх БТКУС-ын жагсаалтанд байхгүй бараа хөнгөлөлт эдэлсэн байсныг илрүүлэн 3,160,987.50 төгрөгийн гаалийн албан татварыг нөхөн төлүүлэхээр ажиллаж байна. 02-2131010-25-I01971 мэдүүлгээр мэдүүлсэн бараа нь АПТА-гийн хөнгөлөлт эдлэх БТКУС кодонд байхгүй тул нэн тааламжтай болгуулсан. Гарал үүслийн гэрчилгээ интернэт холбоосоор гарч ирж байгаа боловч тухайн ААН-ийн нэр, бичигдсэн барааны мэдээлэл зөрөх зэргээр хуурамчаар хийх хандлага ихээр гарч байгаа тул ЗТХ-ийн дагуу 11.21-17-оор 2 удаа, 11.21-12-оор 2 удаа 10'000'000 төгрөгийн торгууль ногдуулан арга хэмжээ аван ажилласан. | | |
| 8 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1. Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнана. | 1.ГЕГ-ын БАҮХ-тэй хамтран "Улсын чанартай томоохон төсөл, арга хэмжээ"-ний хүрээнд 1 төсөл, арга хэмжээний 1757 барааны ангиллын кодыг тодорхойлон ажиллалаа.<br>Энэ ажлын хүрээнд 53 аж ахуйн нэгжийн 966 хуудас бичиг баримтыг хүлээн авч, мэдүүлгийг нягтлан шалгаж, тухайн аж ахуйн нэгжийн үндсэн хөрөнгийн бүртгэлийг https://inspectorebalance.mof.gov.mn/#iss=https%3A%2F%2Fauth.itc.gov.mn%2Fa | 2025.01.01<br>2025.06.10 | 94% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | uth%2Frealms%2FITC сайтаар шалган, 180 гаалийн мэдүүлгээр мэдүүлсэн тоног төхөөрөмжийн нийт 6.7 тэрбум төгрөгийн гаалийн татварын жагсаалтыг гаргасан.<br>2. ГЕГ-ын ТОГ-тай хамтран хуулийн хүрээнд татвар буцаан олголтонд хамрагдах ААН байгууллагын жагсаалт гарган ажилласан.<br>Харин 2023 онд хийгдсэн бүрдүүлэлт, ЗГ-ын 107 дугаар тогтоолд хамаарахгүй бараатай холбоотой 5 аж ахуйн нэгжийн 13 мэдүүлгийн талаар аж ахуйн нэгжтэй нь холбогдон нийт 47,612,793.21 төгрөгийн гаалийн татварыг хөнгөлөхгүй болохыг тайлбарлаж ажилласан. Үүнд:<br>1. Гоёлкашмер ХХК-ний 04-2141002-24-I30086 мэдүүлгийн 2 дахь бараа нь БТКУС-ын 8452.29.00 кодонд хамруулж "оёдлын машин" гэж мэдүүлсэн бараа байсан болович дагалдах бичиг баримтаараа "оёдлын машины толгой" буюу эд анги байсан /гаалийн татварын дүн нь 431,555.29 төгрөг/,<br>2. Фрешбокс ХХК-ний 04-2161001-24-I30119 мэдүүлгийн 2 дахь бараа нь тогтоолд хамаарахгүй бараа байсан /гаалийн татвар нь 1,613,387.96 төгрөг/,<br>3. Жүр-Үр ХХК-ний 02-2131010-24-I32188, 02-2131010-24-I32192, 02-2131010-24-I32324, 02-2141023-24-I32930, 04-2131007-24-I30166 мэдүүлгүүдээр мэдүүлсэн бараанууд нь хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах зориулалттай үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх тоног төхөөрөмж биш, хэрэглээний зориулалттай цахилгаан бараанууд байсан /гаалийн татварын дүн 1,846,351.27 төгрөг/,<br>4. БОСА кондитер ХХК-ний 02-2201004-24-I33208, 02-2091006-24- | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | I32756, 03-2161001-24-I35649, 03-2161001-24-I35650 мэдүүлгүүдээр мэдүүлсэн бараанууд нь БТКУС код, нэршлээрээ тогтоолд хамаарахгүй тоног төхөөрөмж болон эд ангиуд байсан /гаалийн татвар нь 23,664,398.68 төгрөг,<br>5. Хүнскомплекс ХХК-ний ирүүлсэн 02-2211021-23-I31532, 02-2181005-23-I30418 мэдүүлгүүд нь 2023 онд хийгдсэн бүрдүүлэлт байсан /гаалийн татварын дүн 20,057,100.01 төгрөг/ | | |
| 9 | Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | 1. Хууль тогтоомж, эрх зүйн актыг хэрэгжүүлж ажилласан талаар хугацаанд нь тайлагнасан байна.<br>2. Гаалийн бүрдүүлэлттэй холбоотой хууль тогтоомж, журам, зааврыг боловсронгуй болгоход санал санаачлагатай ажилласан байна. | 1. Хууль тогтоомж, эрх зүйн актыг хэрэгжүүлэн, хэрэгжилтийн талаар тайланг хугацаанд нь гаргаж, ГЕГ-ын холбогдох нэгжүүдэд хүргүүлэн ажиллаж байна. 2025 оны эхний хагас жилд хугацаа хоцроосон тайлан, мэдээ байхгүй болно. ГТХ, ГТГТТХ зөрчсөн нийт 213 зөрчлийг илрүүлэн Зөрчлийн тухай хуулийн 9 зүйлчлэлээр 245,4 сая төгрөгөөр торгож, 267,7 сая төгрөгийн татварыг нөхөн төлүүлэн нийт 513,11 сая төгрөгийг төлүүлсэн байна. Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа 4 хэрэгт БЦТ-ийн 10, давах шатны шүүхэд 1 хэрэгт 3 нийт 13 алба хаагч итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон оролцож байна.<br>2. Гаалийн бүрдүүлэлт, холбогдох хууль тогтоомж, журам, зааврыг боловсронгуй болгоход санал санаачлагатай ажиллан нийт 7 журам, зааварт өөрчлөлт оруулах саналыг гарган ГЕГ-ын холбогдох нэгжүүдэд 7 дотоод зурвасаар хугацаанд нь хүргүүлэн ажилласан. Гаалийн бүрдүүлэлтийн хэвийн үйл ажиллагааг хангах, хүндрэл чирэгдэлийг шийдвэрлэхэд чиглэсэн санал гаргаж, зөвлөмж, чиглэл хүссэн 20 дотоод зурвасыг ГЕГ-ын холбогдох | 2025.01.01<br>2025.06.10 | 92% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нэгжүүдэд хүргүүлэн ажилласан байна. Мөн бүрдүүлэлтийн цахим төвийн дүрмийн төслийг боловсруулж, батлуулах ажлын хүрээнд дүрмийн төслийн боловсруулан ГЕГ-ын ЗУГ-т 2025.05.19-ны өдрийн №576 тоот дотоод зурвасаар хүргүүлсэн. | | |
| 10 | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1. Бүрдүүлэлтийн цахим төвийн эрсдэлийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлж, эрсдэлийг таньж тогтоосон, ангилж санд бүртгэсэн байна. | Бүрдүүлэлтийн цахим төв нь тус төвийн дотоод эрсдлийг тодорхойлох зорилгоор албан хаагчдын санал, гомдол мэдээллийн утсанд ирсэн мэдээллийг үндэслэн тодорхойлж ГЕГ-ын А/432 тоот тушаалаар баталсан журмын хавсралтад зааснаар эрсдлийн түвшинг тодорхойлсон. Эрсдлийн түвшинг тодорхойлохоор албан хаагчдаас googleform программаар 2025 оны эхний хагас жилийн судалгаа авч нэгтгэн ажлын ачаалал өндөр байгаа нь дундаас дээш ажлын ачааллаас үүсэх эрсдэл тохиолдох магадлал өндөр гэсэн матрицийн дүгнэлт гарсан.<br>Мөн дотоодод үүсэх гаалийн улсын байцаагчдыг авлига ашиг сонирхолын зөрчит гаргах эрсдэлээс хамгаалах зорилгоор сургалт зохион байгуулсан. Барааны үнэ татвар бууруулах зөрчил удаа дараа гарч байсныг судалгаа хийн анхааруулга өгсний үр дүнд гаалийн бүрдүүлэлтэд дахин нэхэмжлэх үүсгэх асуудал 2024 оны мөн үеэс эрс буурсан. Кайс програмд зохих өөрчлөлтүүдийг хийлгүүлэн бичиг баримтын шалгалт хийж нэхэмжлэл үүсэх цаг хугацааг нарийвчлан гаргадаг болгосон.<br>Бүрдүүлэлтийн явцад гарч буй маргаан, гомдол мэдээллийг Гаалийн байгууллагын 1800-1281 тусгай дугаарын утаст нэгдсэн журмаар авдаг болсон. Утасны бүртгэл мэдээлэлд сар бүр дүн шинжилгээ хийж, мэдээллийн үр дүнг харгалзан ГУБ-ын ажил дүгнэх | | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үзүүлэлтэд харгалзан үнэлгээг өгдөг болсон.<br>Тус төвд 2025 оны 04-р сар хүртэл 1800-1281 тусгай дугаарын утасны 2 шугамыг ажлуулж байсан ба дуудлага, мэдээллийн тоо ихэссэн тул 3 шугам болгон БТКУС хэсэгт ажиллаж буй 2 ГУБ, 1 мэргэжилтэнг тус утасны дуудлага мэдээллийг хүлээн авах https://cerp.ecustoms.mn ийн дуудлагын төв цэсэнд бүртгэж байх талаар зохих арга хэмжээг авсан.<br>4 сараас эхлэн 1800-1281 тусгай дугаарын утаст ирж буй дуудлага бүртгэл, алдагдсан дуудлагад дүн шинжилгээ хийж ажиллаж тус дуудлагыг ГУБ-ын сарын ажлыг үнэлэх үзүүлэлтэд нөлөөлүүлэн тооцдог болсон.<br>БЦТ-ийн БТКУС хэсэг буюу гомдол, мэдээлэл хүлээн авах хэсгийн аюулгүй байдлыг хангахын тулд 2025 оны 03-р сараас тус өрөөнд телехяналтын 1 камер, ГУБ нарын ажлын цаг ашиглалтыг сайжруулах хяналтыг сайжруулах, бүрдүүлэлтийн явцад нягтлан шалгах нэмэлт баримт мэдээллийг гарган өгч буй үйл явцыг баримтжуулах ГУБ нарыг ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх үүднээс БЦТ-ийн 2 давхарын үүдний хэсэгт 1 камерыг тус тус нэмж байршуулсан.<br>БЦТ-ийн дарга тус телекамерын хяналтыг тавих эрхийг ШУТ-д уламжлан авсан. Телекамераар албан хаагч нарыг ажлын цаг ашиглалтыг хянаж ажиллаж байна. | | |
| **Зорилт 4. Соён гэгээрүүлэх** | | | | | | | |
| 11 | Үүрэг даалгаврын биелэлт | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | 1. ГЕГ-ын удирдлага, Захиргааны зөвлөл, мэргэжлийн зөвлөл, шуурхай хуралдаанаас | Тайлант хугацаанд ХШҮДАГ-аас ирүүлсэн 9 зөвлөмжийн дагуу биелэлтийг хугацаанд нь оруулж тайланг хүргүүлэн. ТОГ-аас ирүүлсэн 4 | 2025.01.01<br>2025.06.10 | 94% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | өгсөн зөвлөмж, чиглэл, үүрэг даалгаварыг хэрэгжүүлж, биелэлтийг хугацаанд нь гаргаж тайлагнасан байна.. | удаагийн үүрэг даалгавраас 3 үүрэг даалгаврын тайланг тухай бүр хүргүүлж дүгнүүлсэн, 1 үүрэг нь даалгавар дангаараа хэрэгжүүлэх боломжгүй, чиг үүргийн хүрээнд хэлцлийн үнийн мэдээллийн санд мэдээлэл оруулсан. Захиргаа удирдлагын газраас ирүүлсэн 1 зөвлөмж, цаг үеийн шинжтэй 2 үүрэг даалгаврыг биелүүлэн, тухай бүр тайланг оруулсан. | | |
| 12 | Ажлын цаг ашиглалт | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | 1.ГБ-ын хөдөлмөрийн дотоод журмын 9.3.4-т заасны дагуу "Гаалийн удирдах төв байгууллагын албан хаагч гадуур ажиллах, албан томилолтоор ажиллах, ээлжийн амралтаа эдлэх, чөлөө авах тохиолдолд харьяалах нэгжийн дарга нь Захиргаа, дотоод ажлын систем /CERP/-ийн холбогдох цэсэд хүсэлтийг илгээж ЗУГ-ын цаг ашиглалт хариуцсан ГУБ-д мэдэгдэж ажиллана.<br>2. Нэгжийн ажлын цаг ашиглалт 92 хувиас доошгүй байна. | Өмнөх оны мөн үед ажлын цаг ашиглалт 95 хувьтай байсан бол тайлант хугацаанд 97.28 хувь буй өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.28 хувиар өссөн үзүүлэлттэй байна. | 2025.01.01<br>2025.06.10 | 100% |
| 13 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | Эхний хагас жилд:<br>1. "Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт"-ийг 30-аас доошгүй ААН, иргэн бараагаар хийж ЭУХ-т хүргүүлсэн байна.<br>2. Бүрдүүлэлтийн дараах шалгалтад хамруулах ААН-ийн нэрсийг тухай бүрт нь ГЕГ-ын | 1. "Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт"-ийг боловсруулан эрсдэлийн зөвшөөрөгдсөн шалгуурт 28, үл хамаарах шалгуурт оруулах 4 нийт 32 ААН-ын саналыг гарган судалгааны хамтаар ГЕГ-ын ЭУХ-т 2025.02.26-ны өдрийн №226, 2025.06.03-ны өдрийн №652 тоот дотоод зурвасуудаар хүргүүлсэн. /2024 оны эхний хагас жилд 19 ААН-д ЭШҮХ-ийг боловсруулан ГЕГ-ын ЭУХ-т хүргүүлж байсан бол тайлант | 2025.01.01<br>2025.06.10 | 96% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | холбогдох нэгжид хүргүүлсэн байна.<br>3. Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилтийг үнэн зөв тайлагнана. | хугацаанд 13 ААН-ээр их буюу 68 орчим хувиар өссөн байна/<br>2. ГТХ-ийн 249.1-д заасны дагуу гаалийн бүрдүүлэлтийн үнэн зөвийг нягтлан шалгуулахаар 2025.03.18-ны өдрийн №279 тоот дотоод зурвасаар 3 ААН-ын нэрийг, 2025.04.29-ний өдрийн №470 тоот дотоод зурвасаар 1 ААН-ын нэрийг нийт 4 ААН-ын нэрийг ГЕГ-ын дэргэдэх БДШГ-т хүргүүлсэн. Мөн бичиг баримтын бүрдүүлэлтийн явцад нийт 244 ААН-д БДШ-тад хамруулах саналын кодыг сонгон давхардсан тоогоор 352 удаа CAIS програмд санал оруулсан байна.<br>3. Төвийн 2025 оны гүйцэтгэлийн, 2025 онд хийх ажлын календарчилсан, 1-р улирлын, сарын, 7 хоногийн болон ТЖАХ-ийн 2025 гүйцэтгэлийн төлөвлөгөө гэх мэт 31 төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг нь хангаж, хугацаанд нь тайлагнан ажилласан байна. Мөн төвийн үйл ажиллагаатай холбоотой авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн төлөвлөгөөг тухай бүрт нь боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>- БЦТ-ийн ГУАБ нарын ажил, амралтын хуваарийг 6 удаа, ГУБ нарын ажил амралтын хуваарийг 7 хоногоор 20 удаа, сараар 1 удаа хийж, батлуулан хяналт тавьж ажилласан. Мөн ГУАБ, ГУБ нарын давхар хариуцсан ажил болон хариуцсан БТКУС-ийн бүлгийн хуваарийг тус бүр 1 удаа хийж, хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>- Архивын чиглэлээр "Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт"-ыг боловсруулан, 2025.02.18-ны өдрийн 25/03 дугаар хурлаар хэлэлцэж баталсан. 2025 онд үүссэн 2 чиглэлээр 13 хавтас архивласан. Үүнд: | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | • Ирсэн хүсэлт- 1 хавтас<br>• БТКУС-ийн шийдвэр- 12 хавтас<br>Цахим бүртгэлийн /edoc систем/-д 2025 оны эхний хагас жилд дараах чиглэлээр баримтууд хадгалагдсан байна. Үүнд:<br>• Явсан бичиг – 116,<br>• Ирсэн бичиг – 299 дотоод зурвас байна.<br>• Ирсэн 299 дотоод зурвас үүнээс:<br>□ хариутай 107,<br>□ хариугүй 192 байна.<br>• Хариутай 107 дотоод зурвасын хариуг хугацаанд нь холбогдох нэгжүүдэд бүрэн хүргүүлж ажилласан байна. | | |
| | Нийт | | | | | | 93.6 |

## Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Төрийн байгууллага албан хэргээ крилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна гэсний дагуу Монгол бичгийн мэдлэгээ дээшлүүлнэ. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр, | - | Монгол бичгийн мэдлэгээ албан бичгийн хүрээнд дээшлүүлсэн байна. | Монгол бичгийн мэдлэгээ албан хэрэг хөтлөлтийн хүрээнд мэдлэгээ дээшлүүлэхээр Болорсофт bolorsoft.com-ийн сүүлийн үеийн AI технологи ашиглан КИМО монгол бичиг хөрвүүлэгч /https://kimo.mngl.net// сайт ашиглан Бүрдүүлэлтийн цахим төвийн албан хэрэг хөтлөлтийг хөрвүүлэн өөрийн мэдлэгээ сайжруулсан. Мөн монгол бичгийн толь болон криллээс монгол бичиг рүү хөрвүүлэх youtube суваг ашиглан, өөрийн монгол бичгийн мэдлэгээ дээшлүүлсэн. | 2025.01.01<br>2025.06.10 | 100% |
| 2 | Шинээр гарсан хууль тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ | Хэрэгжилт, гүйцэтгэлээр, | - | Хууль эрх зүйн мэдлэг сайжирч, өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн байна. | Үйл ажиллагаатай холбоотойгоор шинээр гарсан холбогдох хууль, тогтоол, журам, зааварт танилцан үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажиллаж байна.<br>1.Төрийн албаны салбар зөвлөлийн Ёс зүйн дэд хороонд 2024 онд гишүүнээр ажилласанаас хойш хугацаанд Ёс зүйн дэд хорооноос гарч буй хууль тогтоомж дүрэм | 2025.01.01<br>2025.06.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сайжруулах сургалтад хамрагдсан байна | | | | журмыг Бүрдүүлэлтийн цахим төвийн нийт ГУАБ болон ГУБ нарт тухай бүр танилцуулан ажилласан. 2.Мөн 2025 онд Гаалийн бүрдүүлэлтийн чиглэлээр шинээр гарсан хууль, журмыг судалж, хэрэгжилтийг хангаж ажилласан. 2025.01.01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн ГТГТТХ-ийн 38.4, 38.5, 38.6, 38.7, 40.10, 2025.01.23-аас нэмэлтээр орсон ГТГТТХ-ийн 40.11, 2025.06.01-ээс хэрэгжиж эхэлсэн ГТГТТХ-ийн 40.8 дугаар заалтуудын нэмэлт өөрчлөлтүүдийн хэрэгжилтийг хангаж, нийт ГУАБ болон ГУБ нарт хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан. | | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

| | | |
|---|---|---|
| БҮРДҮҮЛЭЛТИЙН ЦАХИМ ТӨВИЙН ДАРГА | Э.ЛХАГВАСҮРЭН / ........................ / | 2025.06.10 |
| *( Албан тушаал )* | *( Нэр, гарын үсэг )* | *( Огноо )* |

## БҮРДҮҮЛЭЛТИЙН ЦАХИМ ТӨВИЙН ДАРГА Э.ЛХАГВАСҮРЭНГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Бүрдүүлэлтийн цахим төв

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт оноо (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | | 61,7 |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийг хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1. | Төрийн байгууллага албан хэргээ крилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна гэсний дагуу Монгол бичгийн мэдлэгээ дээшлүүлнэ. | | 14,5 |
| 2. | Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ сайжруулах | | 14,5 |
| **Мэдлэг. ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо:** | | | 14,5 |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ**

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1. | Хандлага, ёс зүй | 14 |
| 2. | Удирдан зохион байгуулах | 13 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 13 |
| 4. | Манлайлах | 13 |
| 5. | Багаар ажиллах | 13 |
| 6. | Харилцаа | 14 |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 1. | |
| **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо** | | 13 |

## 4. Гүйцэтгэлийн үнэлгээ

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт | 61,7 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 14,5 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ | 13 |
| 4. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт | — |
| **Нийт оноо=** (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо+Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо+Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) – Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо | | 89,2 |

**Үнэлгээ өгсөн:** **Төсвийн шууд захирагч:**

Гаалийн ерөнхий газрын дарга ........................ (Р.Отгонжаргал)

2025.06.25 (огноо)

**Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:** **Нэгжийн дарга:**

Бүрдүүлэлтийн цахим төвийн дарга

........................ (Э.Лхагвасүрэн)

2025.06.10 (огноо)